

БАТТУЛГЫН ГАНХУЯГИЙН Товч намтар

Борчууд овогтой Б.Ганхуяг 1975 онд Улаанбаатар хотод төрсөн.

Яс үндэс Халх. Эрэгтэй. Нийгмийн гарал сэхээтэн. Иргэний үнэмлэхийн регистрийн дугаар [REDACTED] Ам бүл [REDACTED]

Б.Ганхуяг 1983-1993 онд Орхон аймгийн Ерөнхий боловсролын 8 дугаар сургуулийг дүүргэж, улмаар 1997-2001 онд Монгол улсын их сургуулийн Хууль зүйн сургуульд суралцаж, Эрх зүйн бакалаврын боловсрол, 2005-2007 онд Боловсролын их сургуулийн Нийгмийн шинжлэх ухааны сургуульд суралцаж, Улс төр судлаачийн магистрын боловсролыг тус тус эзэмшсэн. Түүнчлэн 2015-2019 онд Боловсролын их сургуулийн докторантурт суралцаж, Улс төр судлалаар докторын зэрэг хамгаалсан.

2011-2012 онд АНУ-ын Харвардын их сургуульд уул уурхай, гэрээ, эрх зүйн чиглэлээр суралцаж, мэргэжил дээшлүүлсэн.

Б.Ганхуяг 1999-2000 онд Монголын худалдаа, аж үйлдвэрийн танхимд мэргэжилтэн, 2001-2007 онд Монголын оюутны холбооны Дэд ерөнхийлөгч, Ерөнхийлөгч, 2005-2008 онд Монгол Улсын Ерөнхийлөгчийн Тамгын газарт Орон тооны бус зөвлөх, 2005-2007 онд "City phone" ХХКомпанийн Гүйцэтгэх захирал, 2007-2013 онд "Эрдэнэс Монгол" ХХКомпанийн хэлтсийн дарга, дэд захирал, 2008-2012 онд Монгол Улсын Засгийн газрын "Таван толгой" төслийн нарийн бичгийн дарга, удирдагч, 2011-2012 онд "Эрдэс Тавантолгой" ХКомпанийн Төлөөлөн удирдах зөвлөлийн гишүүн, 2014-2017 онд Монгол Улсын Их Хурлын гишүүн, Засгийн газрын Шадар сайдын зөвлөх, 2016-2018 онд "Эрдэнэс Тавантолгой" ХКомпанийн Тэргүүн дэд захирлаар тус тус ажиллаж байгаад улмаар 2018 оноос "Эрдэнэс Тавантолгой" ХКомпанийн Төлөөлөн удирдах зөвлөлийн гишүүн, Гүйцэтгэх захирлын үүрэгт ажлыг хийж байна.

Тэрбээр төр, хувийн хэвшил, олон нийтийн байгууллагад ажиллах хугацаандаа тухайн салбар, байгууллагын удирдлага, зохион байгуулалт, тогтолцоо, эрх зүйн үндсийг боловсронгуй болгох, шинэчлэх, бэхэжүүлэх төгөлдөржүүлэх чиглэлээр олон талт үйл ажиллагаа явуулан идэвхи чармайлт гаргаж байгаа залуу боловсон хүчний нэг юм. Нэн ялангуяа оюутан, залуучуудын байгууллагыг биечлэн удирдаж, нийгэмд гүйцэтгэх үүрэг, хариуцлага, бие даасан байдлыг нь дээшлүүлэхэд ихээхэн хичээл зүтгэл гарган анхаарал, санаачлагатай ажилласнаар уг байгууллагын үйл ажиллагаа идэвхиж, нэр хүнд нь боловсролын салбар, иргэд, нийгмийн дунд өссөн байна. Тухалбал, их, дээд сургуулийн Удирдах зөвлөлд оюутны төлөөллийг оруулсан, сургалтын төлбөрт суралцагчийн өөрийн хяналтыг

тогтоосон, дээд боловсролын сургалтын байгууллагын төвлөрлийг саруулах, бүтцийг боловсронгуй болгох, өөрийн удирдлагыг бэхжүүлэхэд анхаарч ажилласан, суралцагчдад тэтгэлэг олгодог болгосон зэрэг нь залуучуудын нийгмийн асуудлыг шийдвэрлэхэд онцгой ач холбогдолтой болж, тэдний сурч боловсрох идэвхийг дээшлүүлсэн, иргэдийн нэн ялангуяа орон нутаг, хөдөөгийн малчид, хөдөлмөрчдийн талархалыг хүлээсэн хүний нэг болж чадсан юм.

Түүнчлэн Б.Ганхуяг нь Монгол Улсын Их Хурал, Засгийн газарт ажиллах хугацаандаа төрийн албаны хэрэг мэдлэг нь тэлж, уул уурайн чиглэлээр гаргасан зарим хууль, тогтоомж, дүрэм, журмын төслийг боловсруулахад биечлэн оролцож, мэдлэг, оюунаа дайчлан зохих хувь нэмрээ оруулсан нь ач холбогдолтой болсон болно. Энэхүү ажилласан туршлагадаа тулгуурлан тэрбээр уул уурхайн салбарт нэн ялангуяа “Тавантолгой” том төслийг үүсгэн буй болгох, хөдөлгөх, хөгжүүлэхэд санаачлага гарган бүхий л хүч чармайлт, чадлаа дайчлан хөдөлмөрлөж, ихээхэн амжилт гаргаж байгаа манай залуу удирдагчдын нэг юм.

Б.Ганхуяг 2018 оноос “Эрдэнэс-Тавантолгой” ХКомпанийн Гүйцэтгэх захирлаар ажилласнаар уг байгууллагын засаглал, бүтцийг сайжруулан ажилсаг хамт олныг бүрдүүлэх, хөдөлмөрийн бүтээмжийг нь дээшлүүлэх, үйлдвэрлэлд орчин үеийн техник, технологийг нэвтрүүлэх, үйлдвэрлэлийн болон бүтээгдэхүүний үр ашиг, үнэ цэнийг нэмэгдүүлэх, санхүү, эдийн засгийн чадавхи, нөөцийг буй болгох, том бүтээн байгуулалтыг эхлүүлэх, гадаад худалдаа, хамтын ажиллагааг өргөтгөх, нийгмийн хариуцлагыг дээшлүүлэх нэн ялангуяа улс орны эдийн засгийг сайжруулах, хөгжил дэвшлийг түргэтгэх зэрэг чиглэлээр олон талт арга хэмжээг авч, үр бүтээлтэй ажиллаж байна. Нөгөөтэйгүүр зөв менежмент хэрэгжүүлвэл төрийн өмч давамгайлсан компани, байгууллага ч ихээхэн ашигтай, үр дүнтэй ажиллаж болдог гэсэн сонгодог жишээг улс орондоо харуулж чадсан нь түүний удирдах ур чадварыг илтгэж байгаагийн нэг илэрэл болж байна.

Ийнхүү олон талт арга хэмжээг авч хэрэгжүүлснээр “Эрдэнэс-Тавантолгой” ХК-ийг бүхий л талаар хөл дээр нь бүрэн зогсоож, эх орныхоо нэр хүндтэй байгууллагын нэг болгож чадлаа. Тус ХК-ийн төлөвлөгөөт зорилт нь сүүлийн жилүүдэд даван биелэгдэж, үр шимээ өгч байгаа нь улс орны өмнө хүлээсэн үүргээ хэрэгжүүлэх боломж бүрдэж, иргэдийн талархалыг хүлээж байна. Тухайлбал, 2019 онд “Эрдэнэс-Тавантолгой” ХК нь борлуулалтын орлогын төлөвлөгөөг 16 хувиар, цэвэр ашгийн төлөвлөгөөг 40 хувиар тус тус давуулан биелүүлж, жилийн эцсийн байдлаар 1 их наяд төгрөгийн цэвэр ашигтай ажиллаж чадсан нь улс орны эдийн засгийн чадавхийг сайжруулахад онцгой ач холбогдолтой болж байна.

Байгууллагынхаа ажлыг эрчимжүүлж, хөдөлмөрийн бүтээмжийг нэмэгдүүлэн борлуулалтын орлогыг нэмэгдүүлж чадсанаар улс орныхоо гадаад өрийг барагдуулах, бүтээн байгуулалтын ажлыг нэн ялангуяа шинэ төмөр замыг буй болгох ажил, иргэдийн хэрэглээний сайжруулсан түлшний

үйлдвэрлэлийг буй болгоход онцгой үүрэг гүйцэтгэж байна. Нэн ялангуяа Нийслэлийнхээ агаарын бохирдлыг бууруулах, иргэдийнхээ эрүүл мэндийг хамгаалах ажилд үндсэн иргэлт гарсан нь Б.Ганхуягийн нөр их хөдөлмөртэй салшгүй холбоотой болж байна.

Түүнчлэн Б.Ганхуяг Монгол Улсын иргэдэд 1072 ширхэг хувьцааны ашгийг нь хүртээх, тэдний хувьцааг эргэлтэд оруулах, оюутан, залуучуудыг судалгаа-шинжилгээний ажилд дур сонирхолтой болгох, эрүүл чийрэг иргэн болгох, бүс нутгийн иргэдийн амьдралыг сайжруулах, тав тухтай амьдрахад нь туслах зэрэг асуудалд анхаарлаа хандуулан өргөн цар хүрээтэй ажлыг зохион байгуулсан нь компанийн нийгмийн хариуцлагыг дээшлүүлэхэд ач холбогдолтой арга хэмжээ болж байгаа юм.

Б.Ганхуяг нь энэ нөр их хөдөлмөрийнхөө хажуугаар өөрийн мэдлэг боловсролоо дээшлүүлэхэд байнга анхаарч, улс төр, уул уурхайн уялдаа холбоо, үр өгөөжийн чиглэлээр эрдэм шинжилгээ, судалгааны ажил хийж, үр дүнгий нь нийгмийн хүртээл болгохын төлөө чармайн ажилласан манай оюунлаг залуучуудын нэг болж чадсан билээ.

Б.Ганхуягийн хичээл зүтгэлийг төр, засаг өндрөөр үнэлж, Засгийн газрын жуух бичиг, “Алтан гадас” одон, “Боловсролын тэргүүний ажилтан” цол, тэмдэг, “Уул уурхайн тэргүүний ажилтан” цол, тэмдэгээр тус тус шагнасан.

д/д	Ажлын газрын нэр	: Хугацаа	: Эрхэлсэн ажил
	1999-2000 онд Монголын худалдаа, аж үйлдвэрийн танхимд мэргэжилтэн.		
	2001-2007 онд Монголын оюутны холбооны дэд ерөнхийлөгч, ерөнхийлөгч.		
	2005-2008 онд Монгол Улсын Ерөнхийлөгчийн Тамгын газарт Орон тооны бус зөвлөх.		
	2005-2007 онд “City phone” ХХКомпанид Гүйцэтгэх захирал.		
	2007-2013 онд “Эрдэнэс Монгол” ХХКомпанид хэлтсийн дарга, дэд захирал.		
	2008-2012 онд Монгол Улсын Засгийн газрын “Таван толгой” төслийн нарийн бичгийн дарга, удирдагч.		
	2011-2012 онд “Эрдэс Тавантолгой” ХКомпанийн Төлөөлөн удирдах зөвлөлийн гишүүн.		

2014-2017 онд Монгол Улсын Их Хурлын гишүүн, Засгийн газрын Шадар сайдын зөвлөх.

2016-2018 онд “Эрдэнэс Тавантолгой” ХКомпанийн Тэргүүн дэд захирал.

2018 оноос “Эрдэнэс Тавантолгой” ХКомпанийн Төлөөлөн удирдах зөвлөлийн гишүүн, Гүйцэтгэх захирлаар тус тус ажиллаж байна.